

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН  
МЭДҮҮЛСЭН ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ  
ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулан 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлснээр татвар төлөгчийн тоо, төсөвт төвлөрүүлэх орлогын дүнгийн өөрчлөлт болон борлуулалтын орлогын ангиллаар татварын цахим системд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн тоо өөрчлөгдөх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Засгийн газраас өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулиудад тусгагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, валютын ханш өөрчлөгдөхөд төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, мөн өрхийн гишүүдийн тооноос хамааран татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогоор иргэд, өрхийн бодит орлогыг дэмжих боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл татварын бодлогыг шинэчлэхтэй холбоотой асуудлыг цаашид цогцоор, системтэйгээр шинэчлэн нэгдсэн тооцооллыг хийх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг 400 сая төгрөг болгосноор төсвийн орлого буурах дүнгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал 400 сая төгрөг хүртэлх орлоготой татвар төлөгчийн бүртгэлийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед өндөр үнэлгээтэй суудлын автомашинд татвар ногдуулах босго үнийг

100.0 мянган америк доллар буюу валютаар тогтоосныг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нийцүүлэн 360.0 сая төгрөг болгон өөрчлөх зэрэг зарчмын зөрүүтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг 400 сая төгрөг болгон нэмэгдүүлэх зохицуулалтыг иргэн, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдээс өнгөрсөн хоёр жилийн хугацаанд ирүүлсэн саналд үндэслэн хасах, өөрчлөхтэй холбоотой зарчмын зөрүүтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Н.НАРАНБААТАР**